

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА

НИЙТИЙН ЭМХ ЗАМБАРААГҮЙ БАЙДЛЫН ҮЕД ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Б.ДАВААСҮРЭН

ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн
8032 дугаар дамжааны суралцагч, цагдаагийн хошууч;

Б.Одбаатар

ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн
Цагдаагийн удирдлага, стратегийн профессорын багийн
профессор, доктор (Ph.D), цагдаагийн хурандаа

Хураангуй: Нийтийн эмх замбараагүй байдлын тухай ойлголт, нийтийн эмх замбараагүй байдлын үед нийгмийн хэв журам хамгаалсан үйл ажиллагааны туршлага, сургамж, нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед цагдаагийн байгууллагаас нийтийн хэв журам хамгаалах үйл ажиллагааг хэрхэн удирдан зохион байгуулах талаар тодорхойлохыг зорилоо.

Түлхүүр үг: Нийтийн эмх замбараагүй байдал, нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдал.

Нийтийн эмх замбараагүй байдлын тухай ойлголт

Цагдаагийн байгууллага нь хүлээсэн үүргээ амжилттай биелүүлэх зорилтын хүрээнд гадаад болон дотоод орчны нөлөөллийг шинжилж, ирээдүйг урьдчилан тооцоолон, аюул заналаас урьдчилан сэргийлэх, саармагжуулах, даван туулах чадварт суралцан, байгууллагыг шинэчлэн өөрчлөх мэдлэгийг эзэмших асуудал чухалаар тавигдаж байна.

Нийтийн эмх замбараагүй байдал нь олон нийтийн аюулгүй байдлын гол аюулын нэг байдаг.

Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Нийтийн хэв журам хамгаалах. олон нийтийн аюулгүй байдлыг хангах" журам /код 500/-Д дараах байдлаар тодорхойлсон байна.

“Нийтийн хэв журам”-Нийгмийн амгалан тайван байдал, хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж буй нийгэмд тогтсон хүмүүсийн хоорондын харилцааны болон аж төрөх ёсны хэм хэмжээг;

“Олон нийтийн аюулгүй байдал”-Байгалийн гамшиг, гэнэтийн осол болон байгууллага, хүмүүсээс хүрээлэн байгаа орчин, эд зүйл, механизмтай зүй бус харьцсанаас хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгөнд учирч болох хор

хөнөөлийг арилгах, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн эрх зүй, зохион байгуулалт, техникийн хэм хэмжээг; гэж тодорхойлсон байна.

Харин нийтийн эмх замбараагүй байдлыг судлаачид янз бүрээр тайлбарласан байдаг. Багш О.Самбуу “Хэсэг бүлгээрээ хамтарч нийгмийн хэв журам зөрчигдсөнөөр зөрчигчдийн тоо эрс өсөж уг үйлдэл нь бусдад захирагдахгүйгээр өөрсдийн дур зоргоор онцгой танхай шинж чанарыг агуулсан байхыг **нийтийн эмх замбараагүй байдал** гэнэ”² гэж тодорхойлсон байна.

Нийтийн эмх замбараагүй байдал нь гэнэт бий болдоггүй, ихэнх төлөвдөө хүн ам нь төвлөрч, суурин соёл иргэншил хөгжсөн хот суурин газарт тухайн улс орны нийгэм, улс төр, эдийн засгийн хүрээнд хурц хэлбэрээр илэрдэг, ялангуяа олон нийтийг хамарсан жагсаал цуглаанд оролцогч, соёл урлаг, биеийн тамирын арга хэмжээний үед хөгжөөн дэмжигчдийн ажиллагаанаас үүсч болох сөрөг үзэгдэл болох нь ардчилал өндөр хөгжсөн орнуудын жишээнээс харагдаж байна. Жишээ нь:

2004 оны 2 сарын 5-нд Бээжин хотын Миюун дүүрэгт дэнлүүний баярын үеэр 37 хүн бусдын хөлд гишгэгдэн амь насаа алдсан.

2004 оны 5 сарын 9-нд Чечений нийслэл Грозны хотын Динамо стадионд Германчуудыг ялсны ойн баяр тэмдэглэх үеэр дэлбэрэлт болж 10 хүн үхсэн. Үүний дотор Чечений ерөнхийлөгч Ахмад Кадилов, Оросын хойд Кавказын генерал Валери Баранов нар амь насаа алдсан.

2005 оны 1 сарын 25-нд Энэтхэгийн Хинду шашинтнуудын баяр баруун Махарашта мужийн Мандхар Деви сүмд явагдах үед ихэвчлэн эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгшид бусдын хөлд гишгэгдэн 300 хүн амь насаа алдсан.

2005 оны 8 сарын 31-ний өдөр Багдад хотын хойд хэсгийн гүүрэн дээр 1000 орчим хүн бусдын хөлд гишгэгдэн амь насаа алдсан.

2005 оны 8 сарын 16-нд АНУ-ын Виржиниа хотод хямдарсан компьютер авах гэсэн хүмүүс бусдын хөлд гишгэгдэн амь насаа алдсан.

2006 оны 10 сарын 3-нд Хятадын стадионд хийсэн нэгэн концертын үеэр 11 хүн бусдын хөлд гишгэгдэж амь насаа алдсан.

2006 оны 2 сарын 6 нд Филиппин улсын нийслэл Манила хотын спортын цэнгэлдэх хүрээлэнгийн гадаа 93 хүн бусдын хөлд гишгэгдэн амь насаа алдаж, 300 орчим хүн гэмтэж бэртсэн.

Монгол улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах” журам /код 500/

² О.Самбуу. Нийгмийн хэв журам хамгаалах албаны чиглэлээр суралцагсдын гарын авлага. УБ. 2006. 32 дахь тал

2006 оны 1 сарын 2-нд Саудын Арабад 346 мөргөлч бусдын хөлд гишгэгдэн амь насаа алдсан¹.

Манай улс орны хэмжээнд урьд өмнө нийгмийн аюулгүй байдлыг алдагдуулж болох шинж чанартай үйлдэл гарч байсан. Гэхдээ зөвхөн тухайн орчинд үүссэн нөхцөл байдлаас бий болсон. нэгдсэн зохион байгуулалтгүй, аливаа хэтийн бодлого. чиглэлгүй, нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчсөн шинжтэй бодит жишээнүүд нийслэл хотын хэмжээнд байдаг. Тухайлбал:

1964 онд Өргөн чөлөө /Одоогийн Ялалтын талбай орчимд/-нд болсон хятад монгол иргэдийн хоорондын зодоон

1982 онд 20 дугаар дэлгүүр /ОХУ-ын ЭСЯ-ны арын төв зам/-ийн орчимд цэргийн комендат, цэрэг хоёрын хооронд болсон маргаанаас үүссэн ард иргэдийн дуулиант зодоон

1987 оны төв цэнгэлдэх хүрээлэнд болсон залуучуудын шоу тоглолтын үед бий болсон хэсэг бүлэг этгээдийн замбараагүй байдал гэх мэт.

Дээрх жишээнүүдээс үзэхэд тухайн үед Монгол улс социалист нийгмийн тогтолцоотой байсан бөгөөд, 1964, 1982 оны дуулиант зодоонууд нь зөвхөн тодорхой хэдэн хүний үзэл бодлын зөрчилдөөнөөс үүссэн, нийтийн эмх замбараагүй байдлыг үүсгэж болох шинжийг агуулсан зодоон байсан бөгөөд харин 1987 оны төв цэнгэлдэх хүрээлэнд болсон залуучуудын шоу тоглолтын үед болсон эмх замбараагүй байдлыг иргэд хэсэг бүлгээрээ нэгдэн төв цэнгэлдэх хүрээлэнд нэвтрэх гэсэн сэдэлтээр үүссэн нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчсөн хэрэг гэж үзэж болох юм.

2004 оны 06 сард сонгуулийн дараа Сонгуулийн ерөнхий хороо, Үндэсний олон нийтийн телевиз рүү дайрсан

2005.01.12-13-нд жагсаал цуглаанд оролцогчид төрийн ордны хойд талд "мануухай" шатаасан.

2005.04.27-нд Сүхбаатарын талбайд эрүүл нийгэм иргэний хөдөлгөөний пшгүүд төмөр торх нүдэн хашгирч, төрийн ордон руу өндөг, улаан лооль шидсэн.

2005 оны хавар Сүхбаатарын талбайн баруун урд хөрөнгийн биржийн зүүн талд улс төрийн намуудыг дэмжсэн жагсаал цуглаанд оролцогчдын хооронд мөргөлдөөн гарах дөхсөн.

2005.11.17-нд Олон улсын оюутны өдрөөр оюутанууд төрийн ордны 40 орчим цонх, 2 автомашины цонх хагалсан.

2006.02-р сард МАХН-ын төв байр луу дайрч намын тугийг урж шатаасан гэх мэт Улаанбаатар хотод 2006 онд 197, 2007 онд 121, 2008 онд 79 удаагийн жагсаал цуглаан болсон байдаг.

2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод жагсаал, цуглаан зохион байгуулж, хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөгөө эдэлсэн хэдий ч энэхүү жагсаал, цуглаанд оролцогдсон хуулиар олгогдсон эрхээ хэтрүүлж, жагсаал цуглаан тайван шинж чанараа алдан, хүчирхийлэл, эмх замбараагүй байдал болон хувирч, хэд хэдэн хүний амь нас хохирч олон арван цагдаагийн алба хаагч болон жирийн иргэд бэртэж гэмтэн, эд хөрөнгийн ихээхэн хэмжээний хохирол учирсан нь тайван замаар ардчилал, зах зээлд шилжиж чадсан монголчуудын хувьд түүхэнд байгаагүй, гашуун сургамжтай өдөр болсон.

“Хууль хүчний байгууллагын алба хаагчид, удирдах ажилтнуудын ажлын идэвхи санаачлага, мэргэжлийн ур чадвар, дадлага туршлага зэрэг нь дулимаг, ажил хариуцах тодорхой эзэнгүй, тулгарсан асуудал бэрхшээлийг шуурхай шийдвэрлэх бололцоогүй байсны бодит шалгуур нь 2008.07.01-ний өдрийн үйл явдал болсоныг хүлээн зөвшөөрөх биз ээ”.

Энэхүү эмх замбараагүй байдалд оролцсон ард иргэдээс 5 иргэний амь нас хохирч, гэмт хэрэг үйлдсэн, хууль зөрчсөн үйлдэлд 731 хүн баривчлагдан, гэмтэл бэртэл авсан 270 хүнд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэн, 221 хүнийг цагдан хорьжээ. Үймээний үеэр хамгаалалтанд ажилласан цагдаагийн алба хаагчдаас хүнд болон хүндэвтэр гэмтэл авсан 375 алба хаагч байгаа ба энэ гэмтлээс болж ажиллах шаардлага хангахгүй болж насан туршдаа эрүүл мэндээрээ хохирч, зарим алба хаагч амь насаа алдсан тохиолдол ч бий*².

Нийтийн эмх замбараагүй байдлын үед цагдаагийн байгууллагаас нийтийн хэв журам хамгаалах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах

Монгол улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн”³ гэж заасан бөгөөд олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох гол үүрэгтэй байгууллага юм.

Цагдаагийн байгууллага нь тусгайлсан чиг үүрэгтэй төрийн тусгай алба, байгууллагуудтай Цагдаагийн албаны тухай хууль, Тероризмтэй тэмцэх тухай хууль, зарлиг, журамд заасны дагуу мэдээлэл солилцож, хамтран ажиллах

* Ш.Ганболд, Ц.Очгэрэл нар, 2012 он, "Өчигдөр, өнөөдөр, маргааш" номны 5 дахь тал

² Б.Сүхбат."Цагдаагийн шуурхай удирдлагын штабын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт".магистрийн ажил. 2013 он.34 дэх тал

³ "Цагдаагийн албаны тухай хууль". Төрийн мэдээлэл.№.,2017 он

бөгөөд Монгол улсын Ерөнхийлөгчийн 2015 онд “Маш нууц” зарлигаар батлагдсан "Онц байдлын үед хамтран ажиллах журам"-ын дагуу хамтран ажиллана. 2008 оноос хойш үйл ажиллагааны эрх зүйн актууд батлагдаж Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам сайжирсан. Шинэчлэн найруулсан Монгол улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 40 дүгээр зүйлд нийтийн эмх замбараагүй байдлын үед авах арга хэмжээг дараах байдлаар тодорхойлсон.

40 дүгээр зүйл. Нийтийн эмх замбараагүй байдлын үед авах арга хэмжээ

40.1. Цагдаагийн алба хаагч олон нийтийн арга хэмжээний зорилго өөрчлөгдөж, нийтийн хэв журам зөрчигдсөн тохиолдолд тухайн үйл ажиллагааг зогсоох, тараах арга хэмжээ авахыг зохион байгуулагчаас шаардах эрхтэй.

40.2. Цагдаагийн байгууллага нь нийтийн эмх замбараагүй байдлаас урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах арга хэмжээг авна:

40.2.1. төрийн тусгай хамгаалалттай болон улсын онц чухал объектын хамгаалалтыг хүч нэмэгдүүлэх, шаардлагатай бол галт тэрэг, нисэх онгоцны буудал, шатахуун түгээх газар, банк болон бусад объектыг хамгаалалтад авах;

40.2.2. хүн, хуулийн этгээдийн хууль бус эзэмшилд байгаа галт зэвсэг, химийн хорт болон аюултай бодис, байлдааны техник хэрэгслийг хяналтад авах;

40.2.3. согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, хэрэглэхийг хориглох;

40.2.4. ангийн зориулалттай буу, сум хэрэгсэл болон тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн худалдаа, аюултай ачаа тээвэрлэлтийг түр хориглох;

40.2.5. хүн, тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөнийг хязгаарлах, өөрчлөх, шилжүүлэн байрлуулах;

40.2.6. нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж бусдад хүч хэрэглэсэн, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлсэн, эд хөрөнгө устгаж гэмтээсэн, эдгээр үйлдэлд өдөөн турхирсан. татан оруулсан, оролцсон хүнийг баривчлах, албадан тараах, зэвсэг, техник хэрэгслийг хураан авах;

40.2.7. зэвсэг болон хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болох бусад зүйлийг хууль бусаар авч яваа, хадгалж байгаа. эсхүл хэрэглэж болзошгүй хүний бие, тээврийн хэрэгсэл, эд зүйлд үзлэг хийх.

40.3. Нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулагч нь нийтийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

40.4. Нийтийг хамарсан арга хэмжээний үед хэвийн үйл ажиллагаа алдагдаж нийтийн хэв журам зөрчигдсөнийг цагдаагийн байгууллага өөрийн

хүч хэрэгслээр зохицуулах боломжгүй болсон тохиолдолд Терроризмтой тэмцэх тухай хуульд заасны дагуу шуурхай штаб ажиллуулна.

Шуурхай удирдлагын штаб, шуурхай штаб нийтийн эмх замбараагүй байдал бий болсон үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлыг удирдан зохион байгуулахдаа дараах үүргийг гүйцэтгэнэ:

а/нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед ажиллах урьдчилсан, нэгдсэн төлөвлөгөө, зураглалтай байх;

б/нөхцөл байдалтай уялдуулан Зэвсэгт хүчний жанжин штаб, Тагнуулын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газартай хамтарсан төлөвлөгөөтэй байх;

в/цагдаагийн хүрээний байгууллагууд, бусад газруудаас ирсэн хүч, хэрэгслийн гүйцэтгэх үүрэг, байрлах газар, үндсэн болон нөөц хүчний хуваарилалт, зохицуулалтыг хийж, шаардлагатай газруудад хүч нэмэгдүүлэн ажиллуулах;

г/үйл явдлын талаар танилцуулга бичих. Танилцуулгад үүссэн нөхцөл байдал, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, ажилласан хүч, техник, тусгай хэрэгсэл, гаргасан зардал, цагдаагийн байгууллага, алба хаагчид болон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан хохирол, саатуулагдсан, баривчлагдан шалгагдаж буй иргэд, тэдгээрийн эрхийг хэрхэн хангаж байгаа, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал зэргийг тусгасан байна;

д/цагдаагийн төв байгууллагын даргад өндөржүүлсэн бэлэн байдалд шилжих, цуцлах санал өгөх;

е/бие бүрэлдэхүүн, техник, тусгай хэрэгсэл, хувцас, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд үзлэг, тооллого явуулж, учирсан хохирлын талаарх мэдээг нэгтгэх;

ж/бүлэг, байгууллагын үүрэг гүйцэтгэсэн байдалд үнэлэлт дүгнэлт хийж нэгдсэн танилцуулга бичиж Цагдаагийн төв байгууллагын даргад танилцуулах.

Нийтийн эмх замбараагүй байдлын үед цагдаагийн байгууллагыг Цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрээр өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлнэ.

Бүлгүүд нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед ажиллах ажлын төлөвлөгөөтэй байж, сургалт, дадлагыг бие даан тогтмол зохион байгуулна. Жагсаал, цуглааныг албадан тараах, нийтийн эмх замбараагүй байдал, гамшиг, онц байдал тогтоосон үеийн хамгаалалтыг Цагдаагийн төв байгууллагын даргын тушаалаар томилогдсон Шуурхай удирдлагын штаб /Цаашид “Удирдлагын штаб” гэнэ/ удирдаж, хяналт тавина. Уг штабын ажиллах чиг үүргийг цагдаагийн төв байгууллагын дарга батална. Олон нийтийн үймээн, эмх замбараагүй байдлыг эхлэх үед түүнийг таслан зогсоох тактикийг зөв сонгож

авсан байх хэрэгтэй. Аль болох хүч хэрэглэх бус, ухуулга сурталчилгаа хийж, тайлбарлан таниулах аргаар зохицуулахыг хичээх. цагдаагийн алба хаагч өдөөн хатгалга, цуу яриа тараах явдлыг цаг тухайд нь мэдэрч байх нь эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх буюу эхэлсэн үймээнийг газар авахуулахгүй таслан зогсооход тусална. Бусдыг буруу үйлдэлд уруу татаж болзошгүй хүмүүс, өдөөн хатгагчдыг илрүүлж тусгаарлах, хурсан олныг тараах, хууль журам зөрчсөн хүмүүсийг олж илрүүлэх зорилгоор цагдаагийн бусад алба хаагчтай хамтарч ажиллан, зохион байгуулагч этгээдтэй ярилцах, хэв журам зөрчихгүй байх талаар иргэдэд зөвлөх. хусэлт тавих зэргээр эмх замбараагүй байдлыг даамжруулахгүй зогсоох шаардлагатай.

Үйл явдлыг дүрс бичлэг, фото зургаар батимтжуулах, хурсан олны дотор энгийн хувцастай үүрэг гүйцэтгэж тэдний хөдөлгөөнийг саатуулан хориглох эсхүл шаардлагтай зүгт чиглүүлэх, дараа нь дотроос нь бутаргах ссарниулах арга хэмжээг авах, халдлагад өртөх аюултайг ямагт анхааоч ажиллах, ажиллалт хийх, үймээн гарсан газрыг эргэн тойрон хаах, бүслэх, жагсаал цуглаанд идвэхтэй олорцож буй этгээдүүдийг олны дундаас татаж гаргах, үймээн эрчимжиж газар авсан тохиолдолд нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч, усан хөөрөг, утаат хөшиг үүсгэгч үэрэг олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг заавар журмын дагуу хэрэглэх нь зүйтэй.

Цагдаагийн алба хаагч нь нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн аюулгүй байдлыг хангахад чухал үүрэгтэй ба жагсаал цуглааны үед ажиллах сэтгэл зүйн бэлтгэлтэй байж, гүйцэтгэх үүргээ бүрэн мэдсэн, өөрийн аюулгүй байдлыг хангасан, зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгслийг бэлтгэсэн, бусад алба, ажилтнуудтай харилцан ажиллах журмаа бүрэн ойлгосон байх нь чухал юм. Цагдаагийн байгууллага, алба хаагч гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэхдээ дараах тусгай хэрэгсэл, мэх ашигладаг. Үүнд:

- 1/ Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл;
- 2/ Нэг бүрийн тусгай хэрэгсэл;
- 3/ Тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл;
- 4/ Хамгаалах тусгай хэрэгсэл;
- 5/ Самбо, каратэ зэрэг зэвсэггүйгээр тулалдах мэх;
- 6/ Албаны нохой.

Цагдаагийн тусгай хэрэгслийг Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, Нэг бүрийн тусгай хэрэгсэл гэж хоёр ангилах бөгөөд дараах тохиолдолд хэрэглэнэ. “Нийтийн эмх замбараагүй байдлыг болон нийгмийн хэв журмыг булэглэн зөрчиж байгааг таслан зогсоох, байгууллага, иргэдийн мэдэлд байгаа барилга

байгууламж, орон байрыг эзлэн авсан, гудамж замын хөдөлгөөнийг буслэн хаасныг чөлөөлөх зэрэг хэд хэдэн зорилгоор олон хунд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэдэг”. Нийтийн эмх замбараагүй байдал нэгэнт үүссэн тохиолдолд түүнийг таслан зогсоох ажиллагааг явуулах нь ойлгомжтой боловч таслан зогсоох ажиллагаа нь ард иргэдийн амгалан тайван байдал, тэдний амьдралын өдөр тутмын хэм хэмжээг алдагдуулах, зарим иргэдийн амь, бие эрүүл мэнд, эрх чөлөөнд түрэмгийлэн халдах гэх мэтчилэн ихээхэн сөрөг үр дагаврыг дагуулдаг. Нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох ажиллагаанд цагдаагийн байгууллагын хүч хэрэгсэл голлох үүргийг гүйцэтгэх бөгөөд нийтийн эмх замбараагүй байдлын цаашдын өрнөлтийг хязгаарлаж, улсын хэмжээний онцгой нөхцөл байдалд хүргэхгүй байхад анхаарах хэрэгтэй.

Нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох ажиллагааг дараах үндсэн 2 хэсэгт хуваана. Үүнд:

Урьдчилан сэргийлэх /сануулах анхааруулах/ ажиллагаа

Нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, дарах ажиллагаа

Урьдчилан сануулах, анхааруулах арга хэмжээ нь нийтийн эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилсан сэрэмжлүүлэх ерөнхий арга хэмжээний анхдагч хэсэг бөгөөд бодит нөхцөл /онцгой цагийн байдал/ бий болж байгаа үед нийтийн эмх замбараагүй байдлын үйл ажиллагааг хурцадмал хэлбэрээр өрнүүлэхгүй байх талаар урьдчилан авах арга хэмжээ юм.

Цагдаагийн байгууллага нь нийтийн эмх замбараагүй байдлын бодит нөхцөл бүрэлдээд байгаа үед:

-эмх замбараагүй байдлыг хурцадмал байдлаар өрнүүлэхгүй байх /аль болох мөргөлдөөн үүсгэхгүй байх/

-хүч хэрэглэх арга хэлбэрийг ашиглахгүй байх зорилгоор урьдчилан сэргийлэх /сануулах, анхааруулах/ ажиллагааг дараах үндсэн хэлбэр, агуулгаар явуулбал зохино. Үүнд:

Газар орныг судлах, тодорхойлох.

Хяналт /ажиглалт/-ыг тасралтгүй зохион байгуулах.

Эргүүл харуулын албаны үйл ажиллагааг хүч нэмэгдүүлэх.

Орон нутгийн засаг захиргаа, хууль хяналтын байгууллагуудтай хамтарч ажиллах

Эмх замбараагүй байдалд оролцогчийн ажил зохих

Тээврийн хэрэгсэл, явган зорчигчдын хөдөлгөөнд хязгаарлалт хийх.

Иргэдэд тавих захиргааны хяналтын ажиллагааг чангатгах.

Сэтгэцийн өвчтөй болон мансууруулах донтой хүмүүстэй ажиллах.

Төрийн болон төрийн бус байгууллагуудтай холбоо тогтоох.

Олон нийтийн мэдээллийг хүлээн авах, мэдээллийн мөрөөр ажиллах.

Цагдаагийн байгууллагын албаны дотоод хяналт шалгалт хийх.

Цагдаагийн төв байгууллага нь "Оператив ажиллагааны удирдамж", бүдүүвч, зураглал бүхий урьдчилсан ажиллагааны төлөвлөгөө хийж, нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох тусгай ажиллагааг удирдах штабыг байгуулан, удирдах албан тушаалтныг тушаалаар томилон доорх үүргийг тогтвортойгоор гүйцэтгүүлнэ. Үүнд:

Бий болж байгаа нөхцөл байдлын талаар мэдээ мэдээлэл цуглуулах, үнэлэлт, дүгнэлт өгч Цагдаагийн төв байгууллагын даргын шийдвэрийн үндэслэлийг боловсруулах.

Урьдчилсан ажиллагааны төлөвлөгөөнд дурьдсан бие бүрэлдэхүүнд зарлан мэдээлэх дохио, журам зохион байгуулалтыг тогтоох.

Шуурхай удирдлагын штабын үндсэн хүч хэрэгслийг бэлтгэх, хуваарилах, бүлэглэх, байрлуулах, дэлгэх, ажиллагааны боловсруулалтыг хийх.

Нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох тусгай ажиллагааны шийдвэрийг хэрэгжүүлэх, явц байдлыг дүрслэн баримтжуулах, зураг бүдүүвч, бусад дагалдах баримт бичгийг бэлтгэж боловсруулах.

ДҮГНЭЛТ: Улс орны аюулгүй байдал, нийтийн хэв журмыг найдвартай хамгаалах, нийтийн эмх замбараагүй байдлыг даамжруулахгүйгээр таслан зогсоох, цагдаагийн ажилтнуудын аюулгүй байдлыг хангах шаардлагын үүднээс хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох, цагдаагийн байгууллагыг шаардлагатай тусгай хэрэгслээр хангах, түүнийг хэрэглэх арга барилд мэргэшүүлэх, сургах шаардлага гарч байна.

Нийтийг эмх замбараагүй байдлын улмаас нийгмийн хэв журам алдагдсан тохиолдолд цагдаагийн байгууллага үүссэн нөхцөл байдлыг өөрийн бие бүрэлдэхүүн, хүч хэрэгслээр зохицуулах бөгөөд энэхүү хүч хэрэгсэл, бие бүрэлдэхүүн нь тухайн нөхцөл байдлыг зохицуулах боломжгүй болсон нөхцөлд үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтран ажиллах эрх зүйн үндэслэлийг тодорхой тусгах шаардлагатай юм.

САНАЛ: Нийтийн эмх замбараагүй байдлын үеийн тусгай ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө, ажиллагааны тактикийн бичиг баримтуудыг боловсруулж, төрийн байгууллага хоорондын харилцан хамтын ажиллагааг сайжруулах, алба хаагчдын гүйцэтгэх үүрэгт сургаж дадтагажуулах шаардлагатай байна. Цагдаагийн байгууллагын үйл ажиллааг зохицуулж буй хууль тогтоомжийг судлан үзэж, галт зэвсэг хэрэглэх журмыг хульд нарийн тусгаж, ажиллах нөхцөл бололцоог хангах нь чухал байна.

Мөн цагдаагийн байгууллагын бүх шатны удирдах ажилтан нь сэтгэл зүйн бэлтгэлтэй, сэтгэл хөөрөл, гутралаа хянаж чаддаг байх, цаг үе, нөхцөл байдлын мэдээлэлийн дагуу тухайн нөхцөл байдлыг судлан зөв үнэлж, түргэн шуурхай